

Сэлэнгэ сумын Бүрэн дунд сургуульд
хяналт шалгалт хийсэн тухай

Хяналт шалгалтын зорилго

Булган аймгийн засаг даргын баталсан 2017 оны 09 сарын 25-ны өдрийн 01/18 тоот удирдамж, Булган аймгийн засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтыг хангуулах, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Алтанхуяг
2017 оны 09 дүгээр сарын 25-аас ажлын 6 хоног

Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр

Сэлэнгэ сумын Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

Шалгалтанд хамрагдсан объектын талаарх

товч мэдээлэл

Булган аймгийн Сэлэнгэ сумын 1-р багт байршилтай Бүрэн дунд сургууль нь 2016 онд 66 ажиллагсадтай ба үүнээс Удирдах 1, Гүйцэтгэх ажилтан 38, Үйлчлэх ажилтан 17 Гэрээт 10 гэсэн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 онд 1-р гарын үсгийг захирал Б.Ариунтунгалаг, 2-р гарын үсгийг нягтлан бодогч М.Энхбат нар зурж төрийн санд бүртгэлийн 040915101, нэмэлт санхүүжилтын 040915401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

Өмнөх шалгалтын талаар

Булган аймгийн Аудитын газраас тус газрын 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

**Шалгалтын явцад хийгдсэн ажил,
шийдвэрлэсэн асуудал**

Тус байгууллагын 2016 оны касс, харилцахын баримт, няравын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журнал, даргын тушаал, цалин олгох хүснэгт, нийгмийн даатгалын болон татварын, санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан Захирал Б.Шинэбаяр, Нягтлан бодогч Ц.Энхбат, Нярав Б.Отгончимэг,

Нягтлан бодогч асан М.Энхбат нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийлээ.

Санхүүжилт, орлогын талаар:

2016 онд төсвөөс 847822,0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 856909,3 мянган төгрөгийг авч үйл ажиллагааны зардалд 856909,3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангаар:

2016 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1909844,8 мянган төгрөг дээр 23670,7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8124,1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 3219,0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл нэмэгдэж, жилийн эцэст 1944858,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2016 онд бараа материалын эхний үлдэгдэл 95733,6 мянган төгрөг дээр 15413,3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 397,3 мянган төгрөгийн эм боох материал, 247,8 мянган төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэл, 396,0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 6757,7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 57244,8 мянган төгрөгний түлш, шатах тослох материал, 1048,0 мянган төгрөгийн барилга засварын материал, 57252,8 мянган төгрөгний хүнсний материал, 9496,3 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 5655,0 мянган төгрөгийн мал амьтан нэмэгдэж, 17068,5 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 397,3 мянган төгрөгийн эм боох материал, 247,8 мянган төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэл, 396,0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 6757,7 мянган төгрөгийн аж ахуйн материал, 53144,8 мянган төгрөгийг түлш, шатах тослох материал, 1048,0 мянган төгрөгийн барилгын засварын материал, 46855,6 мянган төгрөгийн хүнсний материал, 1105,4 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 10050,0 мянган төгрөгийн мал амьтан хасагдаж оны эцэст 112571,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Өглөг, авлагын талаар: 2016 онд авлага, өглөггүй тайлан баланс гарсан байна.

Төсөвт зардлын талаар /мян.төг/

2015 онд төсөвт зардлыг 847,822,0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 856,909,3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд нийт төсвийн зардлын 61,5 хувь буюу 527,216,0 мянган төгрөгийг цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд, 6,8 хувь буюу 57,993,8 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 0,5 хувь буюу 3,984,9 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 0,1 хувь буюу 986,3 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд, 2,6 хувь буюу 22,506,9 мянган төгрөгийг гэрэл цахилгааны зардалд, 7,0 хувь буюу 59,675,1 мянган төгрөгийг түлш халаалтын зардалд, 0,1 хувь буюу 1,338,0 мянган төгрөгийг цэвэр бохир усны зардалд, 6,6 хувь буюу 57,062,8 мянган төгрөгийг хоолны зардалд, 1,9 хувь буюу 16,458,7 мянган төгрөгийг үдийн цайны зардалд, 6,1 хувь буюу 52,537,6 мянган төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд, 1,0 хувь буюу 9,094,8 мянган төгрөгийг хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардалд, 1,1 хувь буюу 9,711,0 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан зардалд, 1,9 хувь буюу 16,323,3 мянган төгрөгийг төрөөс иргэдэд үзүүлэх бусад тусламжийн зардалд тус тус зарцуулсан байна.

Хоолны өдөрлөг дээрх хүүхдийн тооны талаар:

Дотуур байрны хүүхдийн хоолны өдөрлөг, үдийн цайны өдөрлөг зэрэгт хүүхдийн тоо зөв бичигдэж хүнсний тайлан гарсан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. 2016 оны 12 сарын 19 ны өдрийн төлбөрийн хүсэлтээр нярав Б.Отгончимэгийн хувийн харилцах дансанд галч нарын амрах байр барих зориулалтаар 4,894,240 төгрөг шилжүүлсэн боловч амрах байр бариагүй байгаа ба уг мөнгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй орхигдуулсан байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн /14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага/ заасан заалтыг зөрчсөн байна.

2. Бараа материалыг няравын тайланд орлого аваагүй орхигдуулсан байхад нягтлан бодогч санхүүгийн тайланд орлого зарлага хийсэн байгаа, томилолт бодож олгохдоо томилолтоор ажилласан хоног бөглөгдөөгүй бодолт хийгээгүй томилолтоор олгосон байгаа зэрэг нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтыг зөрчсөн байна.

3. 2016 оны 12 сарын 20 ны өдрийн Б/32 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэл олгохдоо 5-60 хувиар илүү тооцож 3,119,988 төгрөг илүү бодож олгосон, уг тушаалыг дараа нь засаж 10 сар, 11 сар, 12 сард сард хувааж Б/27, Б/29, Б/32 тоот тушаалуудыг гаргасан байгаа зэрэг нь 1996 оны 63/104 тоот Монгол улсын Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3т /Ур чадварын нэмэгдлийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 25 хувиас ихгүй байна./, 2010 оны 08 дугаар сарын 16 ний өдрийн 362/112/183 тоот тушаалаар батлагдсан /ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт /, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./ зэргийг зөрчсөн байна.

4. Цалингийн тооцооны хүснэгт болон гарт олгох хүснэгтэд ажиллагсдын гарын үсгийн бүрдэл дутуу.

5. Бүрэн дунд сургуулийн уурийн зуухнаас халаалтаа авч байгаа Төрийн банкттай халаалтын гэрээг сумын тамгын газар байгуулж гэрээнд тусгагдсан халаалтын зардлыг тамгын газрын няравын хувийн харилцах дансанд 2016 онд 1,937,000 төгрөгийг оруулж ямарч захирамж тушаал шийдвэргүйгээр сургуулийн галч нарт олгосон байна.

6. Шилэн дансны нэгдсэн сайтад бүрэн дунд сургууль нь 2016 онд 148 мэдээлэл байршуулахаас 143 мэдээлэл байршуулж 57 мэдээлэл хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-д /Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 сарын 25-ны өдрийн дотор, сар, улиралын гүйцэтгэлийг дараа сарын 08-

ны өдрийн дотор/, мөн хуулийн 8.2-д /Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ/ заасан заалтуудыг зөрчсөн байна.

7. Жолоочийн тооцооны хуудасыг батлагдсан маягтаар хөтлөөгүй, авсан шатахуундаа тааруулан хөтөлсөн байхад нягтлан бодогч тооцоо бодолт хийхгүйгээр зарлага болгосон байна.

8. Сургуулийн захиралын А, Б тушаалыг үдэж архивлаагүй байна.

**. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа,
зөвлөгөө өгсөн байдал**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 1 актаар 3,119,988 төгрөгний төлбөр тогтоов.

Зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Дүгнэлт

Тус байгууллагад Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.5, 7.7 дахь заалтууд, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэл дутуу, шатахууны тайланг нягтлан бодогч шалгаж хүлээн аваагүй, тооцоо бодолт хийдэггүй, жолоочийн тооцооны хуудасыг авсан шатахуундаа тааруулан бичдэг, нярав бараа материалыг тайландаа дутуу орлого авдаг, агуулахын бүртгэлийг бараа материалд хөтөлдөггүй ур чадварыг жилийн эцэст ажил дүгнээгүйгээр хавтгайруулан олгосон байгаа зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй, захирал, нярав, нягтлан бодогчийн ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

Цаашид авах арга хэмжээний санал

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг биелүүлж ажиллах.

2. Нярав бараа материалын тайланд бараа материалыг бүрэн орлогод авдаг байх.

3. Дотоодын хяналт шалгалтыг сайжруулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ

